

ТӨСӨЛ

“ТЕЛЕКАМЕР ХӨТӨЛБӨР”

Нэг. Хөтөлбөрийн зорилго, зорилт

1.1. Хөтөлбөрийн зорилго: Аймгийн хэмжээнд тавигдсан телекамеруудын хэвийн ажиллагааг хангаж, камерын хяналтын нэгдсэн төв байгуулах, гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг эмзэг цэгүүд, нийтийн эзэмшлийн зам, талбай, авто замын уулзваруудыг камержуулах ажлыг үе шаттай хийж цахим эргүүл зохион байгуулах, иргэдийн амгалан тайван байдлыг хангах, иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшил, өмчлөлийн барилга, байгууламж, эд хөрөнгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангахад хөтөлбөрийн зорилго оршино.

1.2. Хөтөлбөрийн зорилт:

1.2.1. Аймгийн болон сум, суурин газрын гудамж, талбайд улсын болон орон нутгийн хөрөнгө, гадаадын зээл, тусламжаар тавигдсан хяналтын камер, дагалдах тоног төхөөрөмж засвар үйлчилгээг хийж, тогтмол хэвийн ажиллагааг хангах,

1.2.2. Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж талбай, олон нийтийн газар, эмзэг цэгүүдийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулах,

1.2.3. Аймгийн болон сум, суурин газрын гудамж, талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор хяналтын камерын удирдлагын нэгдсэн төв байгуулах, эргүүлийг цахим хэлбэрт шилжүүлэх,

1.2.4 Орон сууцны орц, гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбайг тухайн байр, гудамжны иргэд, оршин суугчдын идэвх, санаачилгад тулгуурлан камержуулах ажлыг зохион байгуулах,

1.2.5 Камерын хяналтын төв байгуулласан гадаад улс орнуудын туршлагыг судалж, алба хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах,

Хоёр. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шат, үйл ажиллагаа

Хөтөлбөрийг 2023-2025 онд хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд дараах ажиллуудыг хийж гүйцэтгэнэ.

Үүнд: 2.1 Нэгдүгээр зорилтын хүрээнд

2.1.1. Нийт тавигдсан камеруудад үзлэг, тооллого хийж ашиглалт, техникийн байдлыг шалгаж нэгдсэн тооцоо судалгааг гаргах,

2.1.2. Хяналтын камер, дагалдах тоног төхөөрөмжүүдийг сүлжээ, дэд бүтцийн засвар үйлчилгээг хийж ашиглалтад бүрэн оруулах,

2.2. Хоёрдугаар зорилтын хүрээнд

2.2.1. Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг газар, цэгт шинээр тавигдах камер болон бусад зардлын тооцоог жил бүр гаргаж шийдвэрлүүлэх,

2.2.2. Шинээр камержуулах шаардлагатай гудамж, зам, талбай, объект цэгийг үе шаттай камержуулах,

2.2.3. Байгууллага аж ахуй нэгжүүдийн хяналтын камерыг нэгдсэн системд холбогдох ажлыг зохион байгуулж, нэг стандарттай болгох,

2.2.4. Гэмт хэрэг, зөрчил, ихээр үйлдэгдэг газар, цэг, байршлын судалгааг гаргах,

2.3. Гурав дугаар зорилтын хүрээнд

2.3.1. Камерын хяналтын удирдлагын нэгдсэн төвийг байгуулах,

2.3.2. Камерын хяналтын удирдлагын нэгдсэн төвд түшиглэн "Гэмт хэргийн хяналтын цогц систем"-ийг хэрэгжүүлэх,

2.4. Дөрөвдүгээр зорилтын хүрээнд

2.4.1. "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль"-д зааснаар тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийг өөрсдийн хөрөнгөөр камержуулах ажилд татан оруулах,

2.4.2. Иргэдийн оршин суух аюулгүй амар тайван амьдрах нөхцөл бололцоог хангахын тулд Сууц өмчлөгчдийн холбоо, сайн дурын байгууллагаас өөрсдийн байр, орц, гудамж, зам талбайгаа камержуулахад төрөөс дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааг иргэд олон нийтэд сурталчлах,

2.5. Тавдугаар зорилтын хүрээнд

2.5.1. Камерын хяналтын чиглэлээр хамтран ажиллах гадаад улсын болон тэдний хөрөнгө оруулалттай компаниудтай санамж бичиг байгуулах,

2.5.2 Туршлага судлах, хөрөнгө оруулалт татах чиглэлээр хамтран ажиллах,

Гурав. Хөтөлбөрийн үр нөлөө, бүтээгдэхүүн, шалгуур үзүүлэлт:

Үр нөлөө: Аймгийн хэмжээнд шаардлагатай /гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгддэг/ цэг объект, гудамж, зам талбайд камерын системийг бүрэн суурилуулж тэдгээрийг нэгдсэн хяналтад оруулна.

Бүтээгдэхүүн: Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудамж, зам, талбай, олон нийтийн газар, цэгүүдийг үе шаттайгаар камержуулж, камерын хяналтын удирдлагын нэгдсэн төвийг бий болгоно.

Шалгуур үзүүлэлт:

1. Аймгийн хэмжээнд шаардлагатай /гэмт хэрэг зөрчил ихээр үйлдэгддэг цэг объект, гудамж зам, талбайн камерын системийг суурилуулж тэдгээрийг нэгдсэн хяналтад бүрэн хамруулж байх,

2. 2025 он хүртэл аймгийн нутаг дэвсгэрт хяналтын камерыг шат дараалалтайгаар суурилуулан үйл ажиллагаанд ашигласан байх,

3. Аймагт холбогдох байгууллагуудын нэг системд хамтран ажиллах боломжийг олгож шаардлагатай мэдээлэл, баримтыг авч ашиглах нөхцөл бүрдсэн байх,

4. Иргэдийн амгалан тайван байдлыг хангах, иргэн аж ахуйн нэгж байгууллагын эзэмшил, өмчлөлийн барилга, байгууламж эд хөрөнгийг хамгаалах, аюулгүй байдлыг хангасан байх,

5. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, замын хөдөлгөөний хууль дүрмийн заалтыг хэрэгжүүлэх, зам тээврийн зөрчил, осол хэргийг бууруулах, замын ачаалал нягтралыг багасгасан байх,

6. Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, үйлдсэн гэмт хэрэг зөрчлийг шуурхай илрүүлэх, таслан зогсоох нөхцөл бүрдсэн байх,

7. Хөтөлбөрийн хэрэгжилтийг дүгнэхдээ 2023 оны жилийн үзүүлэлтийг суурь үзүүлэлт болгон ашиглах бөгөөд хэрэгжилтийн явц болон үр дүнг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

№	Зорилт	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Зорилтод түвшин	
				Үзүүлэлт	Он	Үзүүлэлт
1	Аймгийн гудамж, зам талбайд улсын болон нутгын хоронго зээл, Засвар гадаадын тусламжаар үйлчилгээ тавигдсан хяналтын камер ,хийсэн камер дагалдах тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг хийж, тогтмол хэвийн ажиллагааг хангах	Засвар үйлчилгээ хийсэн камер	Тоо	100	2024	1000
2	Гэмт хэрэг, зөрчил ихээр үйлдэгддэг гудам талбай, олон нийтийн газар, эмзэг цэгүүдийг орон нутгийн төсвийн хөрөнгөөр камержуулах ажлыг үе шаттай зохион байгуулах	Шинээр суурилуулсан	Тоо	150	2024	1000
3	Гэмт хэрэг, зөрчил, зам талбайг хянах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор, хяналтын камерын удирдлагын нэгдсэн төв байгуулах, эргүүлийг цахим хэлбэрт шилжүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт	Хувиар	-	2024	100%

4	Орон сууцны орц, гэр хорооллын гудамж, нийтийн эзэмшлийн талбайг тухай байр, гудамжны иргэд, оршин суугчдын идэвх, санаачилгад тулгуурлан тэдний хөрөнгөөр камержуулах ажлыг зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хувиар	-	2024	100%
5	Камерын хяналтын төв байгуулсан гадаад улс орнуудын туршлагыг судалж, алба хаагчдыг чадавхжуулах сургалт зохион байгуулах	Үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хувиар	-	2024	100%

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө нь улс, орон нутгийн төсөв, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн зардал, Олон Улсын байгууллагын зээл, тусламж болон бусад эх үүсвэрээс бүрүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг нарийвчлан тооцож аймгийн жил бүрийн төсөвт суулгана.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийн хяналт-шинжилгээ үнэлгээний төлөвлөгөө

5.1. Аймгийн Цагдаагийн газраас хөтөлбөрийн хэрэгжилтийн явц үр дүнг хагас, бүтэн жилээр аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан, хэлэлцүүлнэ.

5.2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтэс хөтөлбөрийн зорилт, арга хэмжээг бүхэлд нь хамруулан хэрэгжилтийн явцад хагас, бүтэн жилээр хяналт шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьж хэрэгжилтийг дүгнүүлнэ.

5.3. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хүргүүлсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний санал зөвлөмжийн дагуу цаашид авч хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж Цагдаагийн газар холбогдох байгууллагуудтай хамтран хэрэгжүүлнэ.